



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.07.09 № ХХ/1952
танай _____-ны № _____-т

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ж.ГАНБАТ ТАНАА

Тайлан хүргүүлэх тухай

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.9-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны эхний хагас жилийн дотоод аудитын үйл ажиллагааны тайланг хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.



ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

Д.МӨНХ-ЭРДЭНЭ

• 000255001942

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДҮН ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг шинэчлэн баталсантай холбогдуулан Төрийн захиргааны удирдлагын газрын Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтсийг шинээр байгуулж, 2024 оны 11 дүгээр сараас чиг үүргээ хэрэгжүүлж эхэлсэн.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.1-д "Дотоод аудитын нэгж нь тухайн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч батална." гэж заасны дагуу Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 31 дүгээр тушаалаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Тус төлөвлөгөөнд байгууллагын онцлогт тохируулан Дотоод аудитын ажиллах журам, Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал боловсруулж, батлуулах, мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас 3 төсвийн шууд захирагч, 2 төрийн өмчит үйлдвэрийн газар, 4 нэгжийн чиг үүрэг болон санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хамруулан дотоод аудитыг хийж гүйцэтгэх зэрэг арга хэмжээг төлөвлөсөн. Дотоод аудитын чиглэлээр 2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1.ЗГХЭГ, түүний харьяа байгууллагуудад хэрэгжүүлэх "Дотоод аудитын ажиллах журам"-ын төслийг боловсруулж, нэгжийн даргын хяналтад шилжүүлсэн.

2. ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 15 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 "Өөрчлөлтгүй", 1 "Хязгаарлалттай" дүгнэлт өгч, 11 байгууллагыг түүвэрт хамруулан, нийт санхүүгийн 1,526.2 сая төгрөгийн 44 зөрчил, нийцлийн 3,920.7 сая төгрөгийн 5 зөрчил илэрсэн асуудалд нэгтгэл судалгаа хийж гүйцэтгэн, нийтлэг илэрсэн зөрчил болон эрсдэлийг тодорхойлон, байгууллагын стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулахаар бэлтгэж байна.

3. ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын баталсан 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 316 дугаар тушаалаар Удирдлагын академийн 2020-2024 оны санхүүгийн тайланд дотоод аудит хяналт шалгалтыг хийж, 506.7 сая төгрөгийн 6 алдааг илрүүлэн залруулж, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 5,689.3 сая төгрөгийн 24 зөрчил, худалдан авах ажиллагаатай холбоотой 1,867.5 сая төгрөгийн 3 зөрчил, нийцлийн асуудлаар 13.0 сая төгрөгийн 6 зөрчил тус тус илрүүлж, шалгуулагч байгууллагад ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн ХЭГ/961 дүгээр албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах албан бичгийг хүргүүлсэн.

4. Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2025 оны 01 дүгээр удирдамжаар Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2024 оны санхүүгийн тайланд дотоод аудитын шалгалтыг хийж, 170.0 сая төгрөгийн 2 алдааг илрүүлэн залруулж, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 1,188.3 сая төгрөгийн 12 зөрчил, худалдан авах ажиллагаатай холбоотой 42.4 сая төгрөгийн зөрчил, нийцлийн асуудлаар тус бүр 1 зөрчил илрүүлсэн. Тус шалгалтын дагуу шалгуулагч байгууллагад ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн ХЭГ/1642 дугаар албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах албан бичгийг хүргүүлсэн.

5. Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 2025 оны 02 дугаар удирдамжаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 8,187.7 сая төгрөгийн 8 зөрчил, худалдан авах ажиллагаатай холбоотой 784.4 сая төгрөгийн 3 зөрчил, нийцлийн асуудлаар 4 зөрчил илрүүлж, шалгуулагч байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 08-ний өдөр танилцууллаа. Дотоод аудитын шалгалтаар илэрсэн асуудал, автобаазын тулгамдсан асуудал, байгууллагын үйл ажиллагааг шалгалтын тайланд тусган, ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргад танилцуулж, холбогдох зөвлөмжийг хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

6. Үндэсний аудитын газраас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайланд өгсөн өмнөх оны зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг fas.audit.mn нэгдсэн цахим системд 225.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, 8.1 сая төгрөгийн 2 зөвлөмжийг үнэлсэн.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон түүний харьяа Жэндэрийн үндэсний хорооны 2023 оны санхүүгийн тайланд өгсөн өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг нэгдсэн системд үнэлж, холбогдох байгууллагыг мэдээллээр ханган, хамтарч ажилласан болно.